

**“Хай Би Ойл” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2023.04.24-ны өдрийн ээлжит хурлын
тэмдэглэл**

2023.04.24

Улаанбаатар хот

“Хай Би Ойл” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023 оны 04 сарын 24-ны өдрийн 11 цаг 00 минутанд Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо, 18235 товчооны зам гудамж, 59 тоот хаягт байрлах өөрийн байранд эхлэв.

Хуралд: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Гүйцэтгэх захирал Ш.Амар-Отгон, Нягтлан бодогч О.Ганчимэг хурал зохион байгуулах комиссын гишүүн Н.Батнайрамдал, тооллогын комиссын дарга Ө.Энхтайван, гишүүн Л.Даваагэрэл нар мөн нийт 4 хувьцаа эзэмшигчид саналын хуудсаар, 2 хувьцаа эзэмшигч өөрийн биеэр оролцов.

Хурлын дарга Ш.Амар-отгон: Сайн байцгаана уу. Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа, энэ удаагийн хурал анх удаа өөрийн үйлдвэр болон оффис дээрээ хийж байна.

“Хай Би Ойл” ХК-ийн 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал нээсэнийг мэдэгдье.

Ингээд “Хай Би Ойл” ХК-ийн 2023 оны 04 сарын 24-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийг та бүхэнд танилцуулъя. Нийт 52,118,954 хувьцаанаас нийтдээ 88,95% буюу 46,362,440 ширхэг хувьцаа эзэмшиж буй 6 хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнтэйгээр хурлын ирц бүрдсэн тул хуралаа эхлэж байна.

Өнөөдрийн хурлыг “Хай Би Ойл” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ш.Амар-отгон миний бие даргалах бөгөөд хурлаар хэлэлцэх асуудал болон хурлын дэг, компанийн үйл ажиллагааны талаарх мэдээлэлийг өгнө.

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах
2. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
3. Компанийн ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ийн шийдвэрийн талаарх мэдээлэл /мэдээлэл тул санал хураахгүй./

Миний бие “Хай Би Ойл” ХК-ийн Гүйцэтгэх захиралаар 5 дахь жилдээ ажиллаж байгаа Ш.Амар-Отгон гэж хүн байна. Бид 2022 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг та бүхэнд танилцуулна.

2022 онд “Хай Би Ойл” ХК нь 3 сарын 28-наас ажил эхэлж үйлдвэрийн бэлтгэл ажлаа эхлүүлж, тоног төхөөрөмжиндөө цэвэрлэгээ болон засвар үйчилгээг хийсэн. Мөн “Блүүм Ойл” ХХК-тай 330.0 тн мазут нийлүүлэх гэрээ хийж нийлүүлж эхэлсэн. Бид энэ тайлант хугацаанд ажил үйлчилгээ үзүүлэх 5 байгууллагатай, мазут борлуулах 7 гэрээ, хаягдал тос цуглуулах 26 гэрээг тус тус байгуулан ажиллаж ажил ихтэй жил байлаа.

Байгаль Орчны Яаманд өгсөн төлөвлөгөөт ажлын хүрээнд хийгдэх мод тарих ажлыг “Ногоон Хишигтэн” ТББ-тай гэрээ байгуулж 1га газарт мод тарихаар байсан боловч тус ТББ-ын хариуцлагагүй байдлаас болж мод тарьж чадаагүй. Бид төлбөрийг 100% төлсөн байсан бөгөөд одоо шүүхэд өгч шүүхээр шийдвэрлүүлэхээр болсон.

Борлуултын тухайд: 2022 онд нийт “Наранбулаг хан” ХХК, “Эко асфальт” ХХК, “Тэгшт плант” ХХК, “Блүүм ойл” ХХК, “Хазаарбат” ХХК, “Аашто” ХХК, “Ачлалт баян” ХХК зэрэг 7 компанитай гэрээ байгуулан нийт 1,151.9 тонн мазутыг 713,919.6 сая төгрөгийн борлуулалт хийсэн. Өмнөх оны түүхий эдийн үлдэгдэл 736,839 литр, боловсруулсан мазут нь 1,089,387 литр, 2022 ондоо 707,530 литр хаягдал тос цуглуулсан.

Мөн ажилчидын унаа машин техник хэрэгсэлүүдийн урсгал засвар оношилгоо үйлчилгээнүүдийг цаг хугацаанд нь хийлгэж даатгал татварыг төлсөн. Хот дотор явж түүхий эдээ цуглуулдаг тээврийн хэрэгсэл маань зөвшөөрөл авч явдаг бөгөөд тэрхүү зөвшөөрөлийг хагас жилийн хугацаатайгаар авсан.

Аюултай хог хаягдал цуглуулах дахин боловсруулах үйл ажиллагаа эрхэлдэгтэй холбогдуулаад Байгаль орчны яамтай бол салшгүй холбоотой ажилладаг. Байгаль орчны яаманд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг жил бүр гаргаж өгөөд төлөвлөгөөний биелэлтээ тайлагнаж батлуулдаг. Холбогдох тайлангуудыг цаг хугацаанд нь баталгаажуулж явсан. Тайлант хугацаанд компанийн зүгээс хийгдэх болон хийх ёстой ажилууд бүгд хийгдсэн. Үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүн болох музатаа жилд 1-2 удаа Газрын тосны бүтээгдхүүний шинжилгээний итгэмжлэгдсэн лаборатори “Амбер” ХХК-д шинжлүүлдэг байгаа.

Мөн агаарт үүсэх тоосжилт болон хөрсийг хамгаалах чиглэлийн дагуу газар доор байрлалтай тос хадгалах агуулахын тос буулгах талбайн хэсэг, үйлдвэрийн барилгын зүүн тал, ачиж буулгах эсткадын худгийн суурь, хашааны талбайн урд хэсэг, ажилчдын байрны урд хэсгийн талбай, хог ачих цэгийн суурийг тус тус бетондож хатуу хучилттай болгосон.

Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны нэг хэсэг буюу цахилгаан хангамжийн гол хэсэг КТП630 трансформаторт аюулгүй байдлын үүднээс хариуцдаг мэргэжилийн хүмүүсээр тосыг нь шалгуулж, гүйдлийн трансформатор болон цахилгааны тоолуурыг баталгаажуулж суурьлуулсан. Мөн цахилгаан тоног төхөөрөмж болон цахилгаан эрчим хүчний хэмжих хэрэгслийн үйл ажиллагааны байдалд УБТЗ ЭХУХ-ын 1-р ангиас үзлэг, шалгалт хийгдэж зөвлөгөө зөвлөмжийн дагуу трансформаторын газардуулгыг дахин шинэчилэн хийж баталгаажуусан байгаа.

Байгаль Орчны Үнэлгээ, Газрын төлөв байдал чанарын хянан баталгааны ажил болон Гамшгийн Эрсдэлийн Үнэлгээний тайлангуудын хугацаа дуусч байгаа тул уг ажлуудыг мэргэжлийн тусгай зөвшөөрөл бүхий компаниудтай гэрээ байгуулан ажлыг эхлүүлээд байна. Энэ ажлын хүрээнд хийгдэх хөрс, агаар, худгийн усны шинжилгээнүүд зохих ёсны түвшинд хийгдсэн.

Хаягдал усны дүгнэлтийг жил бүр хийлгэж 1 жилийн хугацаагаар сунгадаг байгаа.

Техникийн ашигласан хаягдал тос дахин боловсруулах галын аюулгүй байдлын дүгнэлтийн хугацаа дууссан тул үйлдвэрийн галын аюулгүй байдлыг хангах үүднээс шаардлагатай зүйлүүдийг нэмж хийн Галын Аюулгүй Байдлын Дүгнэлтийг 2 жилийн хугацаатайгаар авсан.

Манай компани маань улиралын чанартай үйл ажиллагаа явуулдаг жил бүрийн 4 сарын 1-нээс 11 сарын 1 хүртэл ажилдаг байгаа. Өвлийн улиралд ажиллах боломжгүй 2022 оны 11 сараас сул зогсож эхэлсэн. Улаанбаатар хотод аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин болосруулах цуглуулах тээвэрлэх цорын ганц тусгай зөвшөөрөлтэй компани юм. Улаанбаатар хотод авто засварын үйл ажиллагаа явуулдаг ихэнх компаниудтай гэрээ байгуулан хаягдал тосыг нь цуглуулдаг байгаа.

“Хай Би Ойл” ХК нь жилийн эцсийн санхүүгийн тайлангаа гаргаад “Эвиденсе аудит” ХХК-аар аудит хийлгэсэн. 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангын талаар нягтлан бодогч О.Ганчимэг танилцуулна.

Ногдол ашгийн тухайд: ТУЗ-ын ногдол ашиг тараахгүй гэсэн шийдвэрийг танилцуулья аа. Компанийн санхүүгийн жилийн эцсийн тайланд 2022 оны 12 сарын 31-ны үлдэгдэлээр 125,841.7 сая төгрөгийн ашигтай гэж гарсан ч мазут худалдан авсан “Блүүм ойл” ХХК нь мазутын төлбөр болох 108 сая төгрөгийг гэрээний хугацаанд төлөөгүй тул шүүхээр шийдвэрлүүлхээр нэхэмжлэл гаргасан байгаа болно. Энэхүү төлбөр хэзээ төлөгдөх нь тодорхойгүй төлөгдсөн тохиолдолд ирэх жилийн үйл ажиллагааны зардалуудад зарцуулагдах тооцоотой байгаа учраас ногдол ашиг хуваарилахгүй гэсэн шийдвэр гарсан.

“Хай Би Ойл” ХК-ийн нягтлан О.Ганчимэг: “Хай Би Ойл” ХК-ийн нягтлан бодогч О.Ганчимэг байна. Хуралд оролцож байгаа та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргье. Миний бие энэ компанид 13 дахь жилдээ ажиллаж байна. 2022 оны тайлангийн үзүүлэлтүүдийг танилцуулая.

2022 онд манай компани нь /НӨАТ-гүй дүнгээрээ/ нийт 744,226.5 сая төгрөгийн борлуулалтын орлоготой, борлуулсан бүтээгдэхүүний өртөг 185,075.1 сая төгрөг байна. Нийт орлогоос мазутын борлуулалт нь 713,919.6 сая, үзүүлсэн ажил үйлчилгээний орлого нь 30,306.8 сая, хүүгийн орлого буюу шатахууны картын урамшуулалд 348,791 төгрөг, түрээсийн орлого 10,145.5 сая төгрөг тус тус орж ирсэн байна. Манайх хашаан дотроо 2, 3 машин байрлуулан тавиулсаны түрээсийн төлбөр нь орлого гэж орж ирсэн юм. Нийт орлогоосоо ерөнхий удирдлагын зардалд 469,106.1 сая төгрөг зарцуулсан бөгөөд 2022 онд манай компани нь 125,841.7 сая төгрөгийн ашигтай ажилласан.

Нийт гарсан зардалууд

- | | |
|---|--------------------------|
| 1. Цалингийн зардалд | 99,576.3₮ |
| 2. НДШ-д | 26,609.4₮ |
| 3. Ашиглалт болон урсгал засвар үйлчилгээнд | 47,860.0₮ |
| 4. Албан татварт | 92,722.1₮ |
| 5. Түлш шатахуун тээвэрт | 79,120.1₮ |
| 6. Элэгдэл, хорогдлын зардал | 103,215.5₮ |
| 7. Шуудан холбоо, бичиг хэрэг, мэргэжлийн үйлчилгээнд | 14,385.4₮ |
| 8. Бусад зардал | 5,617.4₮ тус тус болсон. |
- Өмнөх оны авлага нь 229,882.1 сая төгрөг, татварын авлага 4,821.3 сая төгрөг дансны өглөг 164,515.2 сая төгрөг байна.
 - Манай компани нь “Шарын гол” ХК-аас 2,282,879.5 сая төгрөгний авлагыг Санхүүгийн Зохицуулах хорооны 2022.01.26 –ны өдрийн 44 тоот тогтоолын дагуу “Шарын гол” ХК-ийн өрийг хувьцаагар солих зорилгоор хаалттай хүрээнд нэмж гаргасан нэг бүр нь 100

төгрөгийн нэрлэсэн үнэтэй 2,253,583 ширхэг хувьцааг 2022.01.31-ний өдрийн 01/45 тоот албан бичгийн дагуу 2022.02.08-ны өдөр “Хай Би Ойл” ХК-д өмчлөх эрхийг шилжүүлэн авч баталгаажуулсан.

- Компанийн найдваргүй авлагын нөөц санд бүртгэлтэй 133,331,936.49 төгрөг бүхий найдваргүй авлагыг тайлан баланснаас хасах ТУЗ-ы тогтоолын дагуу шийдвэрлэсэн. Мөн ТУЗ-ийн шийдвэрээр 50,700,000 төгрөгний үнэтэй 50,700 кг үйлдвэрлэлд ашиглах боломжгүй өтгөн хатсан тосыг акталсан.

За та бүхнээс асуух зүйл байвал асуугаарай.

Хурлын төгсгөлд хурлын дарга Ш.Амар-отгон тооллогын гишүүдээс ирсэн санал хураалтын дүнг танилцуулав:

Тооллогод нийт хувьцаа эзэмшигчдийн 88,95 % буюу 46,362,440 ширхэг хувьцаа эзэмшиж буй 6 хувьцаа эзэмшигчдийн саналын хуудас ирснээс 88,95 % буюу 100% хүчинтэй байлаа.

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай хувьцаа эзэмшигчид 100 % нь зөвшөөрсөн, 0 нь татгалзсан, 0 % нь түдгэлзсэн байна.

2. Компанийн шинэ ТУЗ-ийн гишүүдэд нэр дэвшигчдээс **Т.Батгэрэл 11.1%, Б.Дөлгөөнтамир 11.1%, С.Одгэрэл 11.1%, Б.Пүрэвбаатар 11.1%, Р.Оюунбат 11.1% Ш.Амар-Отгон 11.1%**-ийн санал авч ердийн гишүүдэд сонгогдлоо.

Хараат бус гишүүдэд **А.Харцага 11.1%, Т.Тамир 11.1%, Н.Гүнжидмаа 11.1%**-ийн саналтайгаар сонгогдлоо.

“Хай Би Ойл” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны хуралд маань цаг заваа гарган оролцсон та бүхэндээ баярлалаа.

Хурал 12:05 өндөрлөв.

ХУРЛЫН ДАРГА:



Ш.АМАР-ОТГОН

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

Н.Батнайрамдал

Н.БАТНАЙРАМДАЛ